

Ухаалаг Кассын Систем

SMART STORE ГАРЫН АВЛАГА

Г.Ганзориг, Б.Үүрийнтуяа | 2016.02.08

Гарчиг

<u>Ерөнхий танилцуулга</u>	2
Тохиргоо	3
<u>Хэрэглэгч</u>	4
Tacar	5
<u>Нийлүүлэгч</u>	5
<u>Харилцагч</u>	5
<u>Бараа бүтээгдэхүүн бүртгэл</u>	6
<u>Борлуулалт хийх</u>	8
<u>Буцаалт хийх</u>	10
<u>Бэлэн мөнгө хөтлөлт</u>	10
<u>Орлого авах (худалдан авалт)</u>	11
<u>Зарлага хийх</u>	12
<u>Тооллого</u>	13
Авлага_	14
<u>Үнийн шошго хэвлэх</u>	16
<u>Өдрийн тайлан</u>	17
<u>Товчоо тайлан</u>	17
<u>Борлуулалтууд</u>	18
<u>Буцаалтууд</u>	18
<u>Борлуулалт бараагаар</u>	19
<u>Борлуулалт өдрөөр</u>	20
<u>Ашгийн тайлан</u>	20
<u>Гүйлгээний дэлгэрэнгүй</u>	21
<u>График тайлан</u>	22

Ерөнхий танилцуулга



Smart Store програм нь жижиглэн худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан програм юм. Програмын үндсэн дэлгэцний дээд болон доод хэсэгтээ цэсүүдтэй. Програмын цэс болон бусад товчлуур мөн бөглөх талбар дээр хулганы сумыг удаан байршуулахад тайлбар тэмдэглэлүүд гарч ирнэ.

Дээд цэс

Дэлгэцийн баруун дээд хэсэгт Програмын тухай мэдээлэлийг агуулав. Үүнд програмын видео хичээл болон гэрээ нөхцөл бусад мэдээллийг агуулсан.

• Түгжих товч. Тухайн товчлуураар нэвтэрсэн хэрэглэгчийн солих болон програмыг түр хугацаанд түгжихэд ашиглана.

≌ Борлуулатт (F1) товчоор бараа үйлчилгээг кассаар борлуулж бичилт хийнэ. Гараас F1 (хуудас 8)

📕 Бушит (F2) Борлуулсан барааны бичилтийг дуудаж буцаах дэлгэцийг дуудна. Гараас F2 (хуудас 10)

👼 Балжиниете (Б) Кассны бэлэн мөнгөний гүйлгээг хянах дэлгэцийг дуудна. Гараас F3 (хуудас 10)

Â	Борлуулсан бараа	а үйлчилгээний мэ	дээллийг илгээх	товч. Тухайн г	товчлуурыг ,	дарсанаар та	НӨАТ-ын
урам	ишууллын системд	, холбогдон Сугала	ааны мэдээллийг	авна.			

Грограм шинэчлэх товчийг товшиход дараах дэлгэцийг дуудна. Тухайн дэлгэцэн дээрх шинэчлэх товчлуурыг дарахад програмыг шинэчлэх юм. Програм шинэчлэхэд таны оруулсан барааны мэдээлэл болон түүх зэрэг өөрчлөгдөхгүй бөгөөд Манай програмын алдаа болон нэмэлт өөрчлөлтүүд шинэчлэгдэн засварлагдана.



0	Програм шинэчлэх 🛛 🗖 🗙	
	Шинэчлэлт эхлүүлэх]
Татсан хэмэ	жээ : О	

Доод цэс



Баруун доод өнцөгт байрлах компютерийн гарны зурагтай товчлуур нь мэдрэгчтэй (touch screen) дэлгэцэнд зориулсан гар (keyboard) ажиллуулна. Windows 7, Windows 8 болон түүнээс сүүлд гарсан үйлдлийн системд тохиромжтой.

\bigcirc

Ухайн товчлуур нь Teamviewer програмыг ажилуулна. Teamviewer нь интернет-д холбогдсон төхөөрөмжүүдийг алсаас удирдахад зориулагдсан програм юм. Уг програмын тусламжтай Системийн инженээрээс туслаж сургалт авахад зориулагдсан.

Тохиргоо товчлуур нь Програмын ашиглаж буй төхөөрөмжүүд болон ажиллах горимыг тохируулах дэлгэцийг дуудна. (хуудас 3)

Доод цэсэнд үндсэндээ БҮРТГЭЛ, ГҮЙЛГЭЭ, ТАЙЛАН гэсэн үндсэн 3 цэсэнд дэд цэсүүд байрлана. Дэд цэс нь програмын дэлгэцүүдийг дуудна.

Програмын дэлгэц нь жагсаалт, бүртгэл болон коммандын цэс зэрэгээс бүрдэнэ.

Тохиргоо

Бизнес нэр : талбарт ААН нэр болон дэлгүүрийн нэрийг оруулна. Энэ нэр нь Кассын талоны дээд талд хэвлэгдэнэ.

Аймаг, **Дүүрэг**: талбарт үйлчилгээ эрхлэгчийн обьектын харгалзах кассын төхөөрөмжийн одоогийн орон нутгийн татварын хэлтэсийн кодыг оруулна. Кодыг дэлгэцийн баруун гар талд байрлах жагсаалтаас КОДыг оруулна. Жишээ нь Танай дэлгүүр Архангай аймагт байрладаг бол ог гэсэн кодыг оруулах юм.

PosNo талбарт кассын дугаарыг оруулна. Хэрэв 1-с олон кассын машинтай бол өөр өөрөөр дугаарлаж өгнө. Дугаарлахдаа 6 оронтой тоогоор дугаарлаарай. *Жишээ нь: Касс 1 – 100001, Касс 2 – 100002 гэх мэт*.

Нөөц бааз авах Нөөц бааз авах нь таныг мэдээлэлээ алдахаас урьдчилан сэргийлж байгаа хэрэг юм. Ямар нэгэн төхөөрөмжийн болон бусад гэмтлээс мэдээлэлээ хамгаалан хадгалж авах юм. **Нөөц бааз сэргээх** Нөөцлөн авсан тухайн үеийн мэдээллийг одоогын байгаа мэдээлэлийг устган өмнөхийг сэргээх юм. *Нөөц бааз сэргээх нь одоогын байгаа мэдээлэл устана гэдгийг сайтар анхаараарай*.

Хэрэглэгч

Хэрэглэгч													
🛨 Шинэ 🔨 З	🛨 Шинэ 🐑 Засах 🥡 Устгах 🔯 Шүүлт 🎑 🤮 😂												
Хэрэглэгч	Кассын эрх	Менежерийн эрх	Буцаалтын эрх	Орлого авах эрх	Зарлага хийх эрх	Хөнгөлөлт хийх эрх	Кассын үнэ өөрчлөх эрх						
• Админ	\checkmark				\checkmark	\checkmark							
H4 4 1/1 P PH 4													
Дэлгэцийн төлөв : Жагсаа	лтаар харах												

Бүртгэл цэсний Хэрэглэгч дэд цэс.

Програм ашиглаж буй хэрэглэгчдэд холбогдох эрхийг түвшингээр нь хэдэн ч хэрэглэгч үүсгэж болно. Шинээр бүртгэхдээ шинэ товчлуурыг товшино(rapaac ctrl + N). Засварлахдаа жагсаалтаас тухайн мөрөнд 2 товших эсвэл тухайн мөрийг идэвхжүүлж байгаад Засах (ctrl + E). Устгах бол жагсаалтын мөрийг идэвхжүүлж байгаад Устгах (ctrl + D) товшино. Жагсаалтаас хайх бол Шүүлт (Ctrl + F) дарж дээд талын хоосон мөрөнд хайх текстийг гараас оруулахад шүүгдэнэ.

Хэрэглэгч: талбарт Хэрэглэгчийн нэрийг оруулна. Жишээ нь "Баяраа" эсвэл " Bayaraa "



Нууц үг талбарт хэрэглэгчийн нууц үг оруулна. Нууц үгийг оруулахгүй байх боломжтой. Тухайн эрхээр өөр хэрэглэгч орохоос сэргийлж нууц үгийг оруулж өгөх юм. Нууц үгийг давтан оруулна. Код болон үсэг оруулах боломжтой.

Кассын эрх өгөхөд Борлуулалт , Бэлэн мөнгө болон туслах эрхүүд өгөгдөх юм.

Менежер эрх өгөхөд Бүртгэл, Гүйлгээ, Тайлан эрхүүд өгөгдөх юм.

Буцаалт эрх Бичилт хийсэн барааг буцаах эсэх эрхийг олгоно.

Орлого авах эрх барааны үлдэгдлийг нэмэх буюу тоог худалдан авалтын гүйлгээг бүртгэх дэлгэцийн эрх.

Зарлага хийх эрх барааны үлдэгдлийг хасах буюу зарлагадах гүйлгээг бүртгэх дэлгэцийн эрх.

Хөнгөлөлт хийх эрх нь борлуулалтын дэлгэцэнд барааг тус бүрээр хувиар хөнгөлөх боломжтой эрхийг олгоно.

Кассын үнэ өөрчлөх эрх нь барааг борлуулж байх үед үнийг өөрчлөн худалдан боломжийг олгоно.

Тасаг

Бүртгэл цэсний Тасаг дэд цэс.

Тасаг бүртгэснээр	Тасаг						_	. D X
барааг ангилах болон тоолоход чухал уурэгтэй.	+ Ши	інэ 灯 Зас	ax	Устгах	Шүүлт	Adabe		\mathcal{A}
Бараа бүтээгдэхүүн	Тасаг код	Tacar	НӨАТ-тэй эсэх	НХАТ-тэй эсэх				
тус бүр тасагт	· 1	Кассын бараа	\checkmark					
хувиарлагдах юм.	2	Талх нарий	\checkmark					
Тасат кол нь	3	Жимс ногоо	\checkmark					
програмаас	4	НӨАТ-гүй б Архи пиво						
өгөгдөнө.								
Тасгын нэр талбарт тухайн тасгийн нэршилийг оруулна.								
НӨАТ-тай эсэх								
тальарт тухаин тасгийн бараанууд НӨАТ-тай бол	нч ч 1/5 Дэлгэцийн т	▶ ₩ < өлөв: Жагсаалта	ар харах					>

НХАТ-тай эсэх талбарт нийслэл хотын татвартай бараануудын тасагт зөвлөнө.

Шинээр бүртгэхдээ шинэ товчлуурыг товшино(гараас ctrl + N). Засварлахдаа жагсаалтаас тухайн мөрөнд 2 товших эсвэл тухайн мөрийг идэвхжүүлж байгаад Засах (ctrl + E). Устгах бол жагсаалтын мөрийг идэвхжүүлж байгаад Устгах (ctrl + D) товшино. Жагсаалтаас хайх бол Шүүлт (Ctrl + F) дарж дээд талын хоосон мөрөнд хайх текстийг гараас оруулахад шүүгдэнэ.

Нийлүүлэгч

зөвлөнө.

Бүртгэл цэсний Нийлүүлэгч дэд цэс.

Нийлүүлэгч нь барааг нийлүүлэгч байгууллагын бүртгэл юм. Нийлүүлэгч нь бараа бүртгэлд заавал сонгох шаардлагагүй талбар юм.

Нийлүүлэгч код нь програмаас автоматаар өгөгдөнө.

Нийлүүлэгч нэр талбарт нийлүүлэгчийн нэршилийг оруулна.

Тэмдэглэл талбарт дурын текст оруулах боломжтой. Үүнд тухайн харилцагч байгууллагын регистер, утас , хаяг зэргийг оруулахад тохиромжтой.

Шинээр бүртгэхдээ шинэ товчлуурыг товшино(гараас ctrl + N). Засварлахдаа жагсаалтаас тухайн мөрөнд 2 товших эсвэл тухайн мөрийг идэвхжүүлж байгаад Засах (ctrl + E). Устгах бол жагсаалтын мөрийг идэвхжүүлж байгаад Устгах (ctrl + D) товшино. Жагсаалтаас хайх бол Шүүлт (Ctrl + F) дарж дээд талын хоосон мөрөнд хайх текстийг гараас оруулахад шүүгдэнэ.

Харилцагч

Бүртгэл цэсний Харилцагч дэд цэс.

Харилцагч гэдэг нь Танай аж ахуйн нэгжээс бараа үйлчилгээг худалан авч буй үйлчлүүлэгчдийн бүртгэл юм . Харилцагч үйлчлүүлэгч бүртгэснээр авлага үүсгэх боломжтой.

Харилцагч код нь програмаас автоматаар өгөгдөнө.

Картын дугаар талбарт тухайн хэрэглэгчид карт үүсгэн дугаарыг оруулах юм. Заавал бөглөх шаардлагагүй.

Харилцагчийн нэр талбарт үйлчлүүлэгчийн нэрийг оруулж өгнө.

Тэмдэглэл талбарт дурын текст оруулах боломжтой. Үүнд тухайн харилцагчын регистер, утас , хаяг зэргийг оруулахад тохиромжтой.

Шинээр бүртгэхдээ шинэ товчлуурыг товшино(гараас ctrl + N). Засварлахдаа жагсаалтаас тухайн мөрөнд 2 товших эсвэл тухайн мөрийг идэвхжүүлж байгаад Засах (ctrl + E). Устгах бол жагсаалтын мөрийг идэвхжүүлж байгаад Устгах (ctrl + D) товшино. Жагсаалтаас хайх бол Шүүлт (Ctrl + F) дарж дээд талын хоосон мөрөнд хайх текстийг гараас оруулахад шүүгдэнэ.

Бараа бүтээгдэхүүн

Бүртгэл цэсний Бараа бүтээгдэхүүн дэд цэс

Ба	араа											_	
	🛨 Шинэ 🌿 Засах 🧊 Устгах 🔯 Шүүлт 🂽 🕵 🚔												
	Хайлт 💿 Бүх бараа 🔿 Үлдэгдэлтэй бараа 🔿 Үлдэгдэлгүй бараа												
	Баркод	Барааны нэр	Үнэ	Бөөн тоо	Бөөн үнэ	Тасаг	Нийлүүлэгч	Тоо ширхэг	Өртөг	Нийт өртөг	Нийт дүн	Сүүлд өөрчилсөн огноо	Тайлбар
	1	Талх	1,500	0	0			-5	1,000	-5,000	-7,500	2016.05.28 15:44:30	
•	628100670373	Липтон цай 25ш	2,500	2,400	5	Кассын бараа		15	2,000	30,000	37,500	2016.06.04 22:43:38	
Ŀ										25 000			
										25,000	30,000		
H	4 4 2/2 ▶ ₩ <												F
1	Цэлгэцийн төлөв : 🔹 🔾	Кагсаалтаар харах											

Бараа бүтээгдэхүүн бүртгэхэд дараах талбаруудыг бөглөх юм. Заавал бөглөх талбарт Барааны Баркод GS1 стандартын код, Барааны нэр,Үнэ, Тасаг сонгоно. Бусад талбарыг заавал бөглөх шаардлагагүй. Мөн бараанд эхний үлдэгдэл оруулахад зөвхөн шинээр бүртгэж байгаа тохиолдолд орох боломжтой. Засварлах юм уу устгахыг хүсвэл Орлого Зарлага гүйлгээгээр хийгдэнэ. Баркод талбарт барааны кодыг баркод уншигчаар оруулах эсвэл гараас оруулна. Мөн ар талын + товчлуурыг дарахад дараах дэлгэц нээгдэнэ. Тухайн дэлгэцэнд ижил төрлийн олон баркодыг нэгтгэн оруулах юм. Жишээ нь : Alpen Gold шоколад нь олон өнгөтэй бөгөөд баркод өөр өөр мөртлөө үлдэгдэл болон үнэ өртөг нь ижил байгаа тохиолдолд баркодыг нэгтгэж өгсөнөөр 1 бараа болгон хадгалагдах юм.

-	~́∰	Барааны нэр	Alpen	Gold L	Јок 150)гр	+	x
				Б	аркод			
•	865	5612345	6					
	865	5612345	7					

Барааны нэр талбарт тухайн барааны нэрийг оруулна.

Бараа нь олон төрөлтэй бол нийтлэг нэрийг оруулах юм. Жишээ нь МСЅ-ын хүслийн ундааг бүртгэхэд Кока кола, Спрайт, Фанта гээд олон нэршил байгаа боловч нийтлэг нэр нь Хүслийн ундаа о,5 гэж бүртгэхэд илүү зохимжтой.

Үнэ талбарт бараа бүтээгдэхүүн үйлчилгээний зарах үнэ буюу худалдах нэгж үнийг оруулах юм. Зөвхөн тоон утга оруулах юм.

Тасаг талбарт бүртгэгдсэн тасгаас сонгоно. Тасаг шинээр бүртгэхийг хүсвэл + товчлуурыг

Баркод		+	Бөөн тоо		0 (• •
Барааны нэр	Барааны нэр		Бөөн үнэ		0 (,
Үнэ		0 ‡	Тайлбар	Тэмдэглэл		
Тасаг	Тасаг сонгох -	+	🗆 Хялб	ар товч болгох	ЭСЭХ	
Нийлүүлэгч	Нийлүүлэгч сон	+	Ашгиин ху	вь%: О	🖌 (Č)	
Нэгж Өртөг		0 ‡		Зураггүй		
Эхний үлдэгдэл		0 ‡				

товшиход ТАСАГ дэлгэцийг дууна. (хуудас 5)

Нийлүүлэгч талбарт тухайн барааны үндсэн нийлүүлэгчийг оруулж өгнө. Хэрэв өөр нийлүүлэгчээс тухайн барааг худалдан авах бол Орлого гүйлгээнд тухайн худалдан авсан нийлүүлэгчээ сонгох боломжтой.

Нэгж өртөг талбарт тухайн барааны нийлүүлэгчээс худалдан авсан үнэ буюу цаанаас ирсэн үнийг оруулна. Зөвхөн тоон бутархай болон бүхэл утга орно.

Эхний үлдэгдэл талбарт тухайн барааны тоо ширхэгийг зөвхөн шинээр бүртгэж байгаа тохиолдолд оруулах боломжтой. Нэгэнт бүртгэгдсэн бол засварлах боломжгүй. Хэрэв өөрчлөхийг хүсвэл Орлого (хуудас 11) гүйлгээгээр тоог нь нэмэх эсвэл Зарлага (хуудас 12) гүйлгээгээр тоог нь хасна.

Бөөн тоо хэрэв тухайн барааг бөөний болон жижиглэнгийн үнээр худалдах бол Бөөн тоо талбарт хэдэн ширхэг эсвэл кг-р зарсан тохиолдолд бөөн үнээр бодогдох тоо ширхэгийг оруулах юм.

Бөөн үнэ талбарт барааны нэгж бөөний үнэ буюу хямдарсан үнийг оруулах юм.

Тайлбар талбарт дурийн текстэн болон тоон өгөгдөл оруулах боломжтой. Мөн барааг сегментлэх боломжийг олгоно.

Хялбар товч болгох эсэх талбарыг бөглөвөл тухайн бараа борлуулах дэлгэцэн товч болон харагдах ба хэрэглэгч заавал кодыг оруулж барааг уншуулах шаардлагагүй товшиход л хангалттай юм.

Шинээр бүртгэхдээ шинэ товчлуурыг товшино(гараас ctrl + N). Засварлахдаа жагсаалтаас тухайн мөрөнд 2 товших эсвэл тухайн мөрийг идэвхжүүлж байгаад Засах (ctrl + E). Устгах бол жагсаалтын мөрийг идэвхжүүлж байгаад Устгах (ctrl + D) товшино. Жагсаалтаас хайх бол Шүүлт (Ctrl + F) дарж дээд талын хоосон мөрөнд хайх текстийг гараас оруулахад шүүгдэнэ.

Хэрэв барааг устгахад "**Тухайн бараа үлдэгдэлтэй тул устгах боломжгүй**" гэсэн мессеж гарч ирвэл барааны үлдэгдэлийг зарлага гүйлгээгээр үлдэгдэлгүй болгоод дараа нь устах боломжтой болох юм.

Борлуулалт хийх

№: 17 🦉	Устгах (Delete)	🧼 Үнэ харах, хэвлэх(F4) 🛛 🔯 Төлбөр (F5) 🖉	Баримт(F6) 🛛 🎉 Карт (I	F7)			\mathbf{O}	08:55:13				
Баркод :	Баркод (F1)	EN										
	Баркод	Бараа	Тоо	Үнэ	НӨАТ	HXAT	Дүн ₮					
628100670373		Липтон цай 25ш	1	2,500	227			2,500				
1		Талх	1	1,500				1,500				
НӨАТ 10%	КАЈОR-РОЗ УХААЛАГ КАССЫН СИСТЕМ 9900-0031, 88003214, 94003214											
Лун (₹)			4.000								
(.,								
БУЦАХ (esc) ТӨЛБӨР Т (F5) Ажлын огноро 2016.06.05 Бугдийг устгах (Shift-Delete) Хенгелелт бараагаар %(F10) Барааны унэ еерчиех (F11) Навторсон Ааминистратор												

Үндсэн дэлгэцийн дээд хэсэгт байрлах Борлуулалт (F1) цэс.

Борлуулалт дэлгэц нь бараа үйлчилгээг бичилт хийхэд зорулагдсан хялбаршуулсан гүйлгээний дэлгэц юм. Хэд хэдэн барааг нэг дор баркодыг Баркод сканераар уншуулж үнийн дүнг бодож төлбөр хийж дуусгах зарчимаар гүйлгээ хийгдэнэ.

Баркод:	Γ	EN									
	Γ	Баркод	Барааны нэр	Үнэ (жиж)	Бөөний үнэ	Tacar	Нийлүүлэгч (
8100670373	٩										
	•	1	Талх	1,500	0						
		62810067	Липтон ца	2,500	5	Кассын ба					
	Γ	8656123456									
	F	8656123457									
	4										
							Copr 33X				

Барааг бичилт хийхдээ баркодыг уншуулахаад гадна барааны нэр, үнэ, тасагаар хайх боломжтой юм. Баркод талбарт идэвхтэй байх үедээ F1 дарахад барааны жагсаалтттай жижиг цонх нээгдэх юм. Хайх бараагаа дээд хоосон мөрний харгалзах багананд бичихэд шүүгдсэн бараанд ENTER дарах эсвэл хулганы зүүн товшилтыг 2 дарна.

Устах (Delete) Бичигдсэн бараа нь буруу бараа эсвэл худалдан авагч авахаа больсон тохиолдолд тухайн

бараанаа мөрөнд идэвхжүүлж байгаад Delete товчлуур дарж тухайн барааг устгана. Мөн Shift + Delete товч хослуулан дарвал Бүх бичигдсэн бараа нэг дор устана.

🖀 🚥 Бичигдсэн барааны тоо ширхэгийг өөрчлөнө. Өөрчлөх гэж буй барааг идэвхжүүлж байгаад F3 дарахад Тоо өөрчлөх жижиг цонх нээгдэнэ. Тухайн цонхонд тоог өөрчлөн ОК товч дарсанаар барааны тоо өөрлчөгдөн Нийт дүн, НХАТ, НӨАТ автоматаар бодогдоно.

Унэ харах, хэвлэх(F4) F4 буюу Үнэ харах Хэвлэх дэлгэц. (ХУУДАС)

🍯 толбор (F5) F5 Бүх барааг үнэн зөв уншуулж нийт үнийн дүнг нягталсны эцэст Төлбөр, Тооцоог хийх юм.

Төлбөр тооцооны цонх тусдаа нээгдэнэ.

Нийт төлөх дүнгийг доод талбарт Төлсөн Үнийн дүнг оруулж өгсөнөөр Үлдэгдэл юмуу хариулт дэлгэцэнд харагдах юм.

• Иргэнд очих баримт

Сонгогдсон үед EBARIMT бүртгэлтэй 8 оронтой хэрэглэгчийн дугаарыг ХЭРЭГЛЭГЧИЙН ДУГААР талбарт бичиж тооцоог дуусгахад тухайн хэрэглэгч EBARIMT - д баримтаа бүртгүүлэх шаардлагагүй болох юм.

• Байгууллагад очих баримт

Сонгогдсон үед заавал Байгууллагын

регистрийг оруулна. Интернет холбогдсон тохиолдолд Байгууллагын нэр гарч ирэх юм. Хэрэв интернет холбогдоогүй тохиолдолд байгууллагын нэрийг гараар оруулж өгч тооцоог дуусгана.

Төлбөр тооцоог дуусгахдаа БЭЛНЭЭР (F5), КАРТААР(F6), АВЛАГААР (F7) гэсэн 3 төрлийн гүйлгээгээр хийгдэх боломжтой. Хэрэв төлөлтийн дүн хүрч байвал Тооцоо дуусч талон хэвлэгдэнэ. Хүрээгүй бол үргэлжлүүлэн төлж байж тухайн гүйлгээ дуусна.

- БЭЛНЭЭР (F6) тохиолдолд худалдан авагч төлбөрийг бэлэн хийсэн тохиолдолд бүртгэнэ. Дүнгээ оруулаад ENTER дарах эсвэл F5 Товчлуураар гүйцэтгэгдэнэ.
- КАРТААР (F6) дарсан тохиолдолд Төлөлтийн дүн бэлэн бусаар хийгдэх юм. Тухайн үйчлүүлэгчийн Бэлэн бус тооцооны дүнг оруулж хийх.
- АВЛАГААР (F7) Үйлчлүүлэгчид бараа үйлчилгээ зээлж байгаа төлбөрийн дараа хийх тохиолдолд авлага үүсгэх юм. Зөвхөн бүртгэлтэй харилцагчид сонгогдох ба тухайн харилцагч нь өмнө бүртгүүлээгүй бол Шинэ харилцагч дарж бүртгэнэ.

Хөнгөлөлт бараагаар % (F10) ХӨНГӨЛӨЛТ БАРААГААР % (F10) сонгогдсон барааны үнийн дүнг хөнгөлөх тохиолдолд тухайн барааг идэвхжүүлж байгаад F10 дарахад барааг хөнгөлөх жижиг цонх нээгдэнэ. Тухайн цонхонд 0-100 хооронд хөнгөлөх хувийг оруулж ОК товч дарна.

Барааны үнэ оөрчлөх (F1) БАРААНЫ ҮНЭ ӨӨРЧЛӨХ (F11) сонгогдсон барааны нэгж үнийг өөрчлөх юм. Барааг идэвхжүүлээд F11 дарахад үнэ өөрчлөх жижиг цонх гарч ирэх ба тухайн цонхонд тоогоор үнийг оруулаад ОК товч дарж НЭГЖ ҮНИЙГ шууд өөрчлөх юм.

99 <u>9</u>				Хариулт 🤇
өлөх	(ДҮН :		4,000	6,000
	10,00	0	(F4)	хөнгөлөлт О НИЙТ ТӨЛБӨР
1	2	3	20000	4,000 төлсөн
4	5	6	10000	БЭЛНЭЭР О
7	8	9	5000	КАРТААР О АВЛАГА
0	СТэг.	лэх	1000	0
иргэнд (очих баримт (F	2) 🔿 Бай	гууллагад очих баримт (F3)	
Хэрэглэгч	чийн дугаар	Регистер	Байгууллагын нэр	

Буцаалт хийх

Буцаалт				- - x	Буцаалт хийхэд
№ : 17 Тоо өөрчлөх (F3)	🔯 Буцаалт бэлнээр (F5)				зайлшгүй өмнө нь
№ : 17	··· 4	цата :			хийгдсэн
Баркод	Бараа	Борлуулсан	Үнэ	Дүн	борлуулалыг буцаах ба тухайн
628100670373	Липтон цай 25ш	1	2,500	2,500	борлуулалтын
1	Талх	1	1,500	1,500	дугаараар дуудаж
					Бүгдийг буцаах болон хэсэгчилсэн буцаах гэсэн 2 төрөлтэй. Хэрэв хэсэгчилсэн буцаалт хийхийг хүсвэл дуудагдсан
~			\mathbf{v}		борлуулалтын барааг
I	Чийт дүн (₮)		идэвхжүүлээд Тоог өөрчлөх (F3) дарж		
Ажлын огноо			н	эвтэрсэн Администратор	тоог өөрчлөн Буцаалт
					бэлнээр (F5) дарж

Үндсэн дэлгэцийн дээд хэсэгт байрлах Буцаалт (F2) цэс

дуусгана. Бүгдийг буцаах бол тоог өөрчлөхгүйгээр шууд буцаах товч дарахад бүгд буцаагдана. Буцаалт нь барааны үлдэгдэл дээр буцаж нэмэгдэж орж ирэх ба хэрэв барааг актлах бол буцаасны дараагаар Зарлага хийж байж актлагдахыг анхаарна уу.

Бэлэн мөнгө хөтлөлт

Үндсэн дэлгэцийн дээд хэсэгт байрлах Бэлэн мөнгө (F3) цэс

Бэлэн мөнгө хөтлөлт нь дотроо 4 төрлийн гүйлгээтэй. Үүнд: Эхний үлдэгдэл, Мөнгө тушаах, Эцсийн үлдэгдэл, Мөнгө орлого зэрэг гүйлгээтэй.

É	Бэлэн мөнг	е Ажлын огно	o:2016.06.05	x
	Гүйлгээний төрөл :	Эхний үлдэгд	эл	-
	Дэвсгэрт	Эхний үлдэгд	эл	
•	20000	Мөнгө тушаа	x	
	10000	Эцсийн улдэг	дэл	
	5000		N	
	1000		,	
	500			0
	100			0
	50			0
	20			0
		0		0 🚽
Д	YH :			₹0
Г	үйлгээний ут	га		
\checkmark	Баримт хэвлэх эсэх			
4	Болих		Хадгалах (F12)	

Эхний үлдэгдэл нь Өдрийн гүйлгээ эхлэхийн өмнөх задгай мөнгө буюу хичнээн төгрөг ямар ямар дэвсгэртээр эхэслнийг бүртгэж өгөх юм.

Мөнгө тушаах нь касснаас мөнгөн зарлага гаргаж байгаа үед тэмдэглэж дэвсгэрт тус бүрээр тоолж бүртгэх юм. Жишээ нь Менежер касснаас мөнгө авах болон Нийлүүлэгчид барааны үнийг кассны орлогоос өгч байгаа тохиолдол тухайн гүйлгээгээр бүртгэх юм.

Эцсийн үлдэгдэл гүйлгээгээр өдрийн бичилт хаагдах үед маргааш хэрэглэх мөнгө үлдээж байгааг тэмдэглэж дэвсгэрт тус бүрээр бүртгэж оруулна.

Мөнгө орлого нь Мөнгө тушаах гүйлгээний эсрэг гүйлгээ гэсэн үг юм. Кассчин мөнгө тушаах үедээ мөнгийг илүү тушаасан тохиолдолд зөрүүг нь Мөнгө орлого гүйлгээгээр хийхэд тухайн өдрийн Бэлэн мөнгө балансаа

барих юм.

Орлого авах

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Гүйлгээ цэсний Орлого дэд цэс

Орлого дэлгэцрүү ороход үндсэн дэлгэцэнд хайх хэсэг болон жагсаалтын хэсэгтэй юм. Өмнө хийгдсэн орлогын эхлэх болон дуусах он сар өдрөөр нь хайлт хийж засварлах эсвэл лавлан харж болох юм.

Шинэ орлого авах бол ШИНЭ товч (ctrl + N) дарахад 2 дахь зурган дахь цонх харагдах юм.

Хэрэв засварлах бол бусад дэлгэцийн адил толгой мөрөнд 2 товших эсвэл идэвхжүүлж байгаад ЗАСАХ (ctrl + F) товчдуураа

Op	юго						
	🕂 Шинэ	3acax	Устгах	Щү	илт 💽 🕅		Ì
	Огноо:	2016.05.05	-aac	2016.0	6.05 - 落	Хайлт	
	Дугаар	Ажлын огноо	Хэрэг	лэгч	Тайлбар	Хаагдсан эсэх	Нийт дүн
Þ	1	2016.05.31	Админ			\checkmark	10,000
							10,000
144	< 1/1 ▷ H						F
Д	лгэцийн төлө	в : Жагсаалтаар харах					

ЗАСАХ (ctrl + E) товчлуураар нээгдэнэ.

Орлогоор барааны үлдэгдэл нэмэх , мөн нийлүүлэгчээс бараа бууж дэлгүүртээ бараа худалдан авалт хийж байгаа үед тухайн гүйлгээг ашиглаж барааны үлдэгдэлийг нэмж бүртгэж байгаа юм. Орлого нь хаагдсан болон хаагдаагүй гэсэн 2 төлөвтэй. Хаагдсан орлого нь барааны үлдэгдэл дээр нэмэгдээд засагдах болон устах боломжгүй болсон Орлого юм. Хаагдаагүй орлого нь хараахан барааны үлдэгдэл нь нэмэгдээгүй засварлах болон устгах боломжтой орлого юм.

Тэгэхээр таны оруулсан орлого барааны үлдэгдэл дээр нэмэгдээгүй бол тухайн орлого хаагдаагүй гэсэн үг юм.

Орлогын дугаар нь автоматаар програмаас өгөгдөнө.

Орлого											_ D X				
Болих С Аугаар : 2 Гүйлгээний у	Болик Царалак Сорлого хаак Срадинак Баримат Гар дугаар: 2 Баркодоор оруулах Гар ГүЙЛГЭЭНИЙ УТГа														
Баркод	Барааны нэр	Нийлүүлэгч	Too	Өртөг	Нийт өртөг	Нэгж үнэ	Нийт үнэ	Ашгийн хувь	Дуусах огноо	Өөрчилсөн	Өөрчилсөн огноо				
• 628100	Липтон цай		1	2,000	2,000	2,500	2,500	0							
1					2,000		2,500				,				
4 C	Illinus Guerra e				2,000		2,500								

Нэг дугаартай орлого шинээр бүртгэхэд хэд хэдэн барааг багцалж оруулах юм.

Гүйлгээний утга талбарт тухайн орлогын шинж чанар онцлогоос хамаарж дурийн утга оруулна.

Баркодоор оруулах барааг баркод уншуулж түүвэрлэх маягаар оруулах юм. Мөн заавал баркод гэлгүй ... – тэй товчлуур дээр нь эсвэл F1 товч дарахад жижиг туслах цонх гарах ба тухайн цонхноос барааг сонгож доош жагсаалт руу буулгаж оруулах юм.

Барааны Тоо ширхэг болон Нэгж өртөгийг өөрчлөх боломжтой. Нэгж өртөг нь барааны нийлүүлэгчээс ирсэн үнэ буюу цаанаасаа авсан үнийг оруулж өгнө. Үнэ болон өртөгийг өөрчлөхөд ашгийн хувь бодогдоно.

Ингээл орлого маань хараахан дуусаагүй бол **Хадгалах** (ctrl + S)дарж хадгалаад буцаж орж засварлах боломжтой. Хэрэв орлого бүгдийг нь бүртгэж дууссан гэж үзвэл **Орлого хаах** (ctrl + T) товшиж орлогыг хаана.

Арилгах товчоор илүү оруулсан барааг устгах юм.

Баримт товчоор тухайн орлогыг хэвлэх боломжтой баримтыг хэвлэнэ.

Зарлага хийх

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Гүйлгээ цэсний Зарлага дэд цэс

Зарлагын гүйлгээ нь барааг актлах, нийлүүлэгчрүү барааг буцаах зэрэг барааны үлдэгдэл хасах тохиолдолуудад тухайн гүйлгээгээр бүртгэнэ . Дэлгэцийг нээхэд Лавлагаа дэлгэц харагдах юм. Тухайн дэлгэцэнд хайлтын хэсэг болон жагсаалтын хэсэгээс бүрдэнэ.

Хайлтын хэсэгт Эхлэн болон дуусах огноогоор хайх боломжтой. Тухайн зарлагыг хэзээ хийсэн он сар өдрөөр нь хайх юм.

Жагсаалтын хэсэгт зарлагын толгой мөрөнд ерөнхий мэдээлэлүүд харагдана. Үүнд Зарлагын огноо, дугаар, нийт үнийн дүн болон ямар хэрэглэгчээр бүртгэсэн зэрэг багануудтай. Шинэ зарлага хийхийн тулд Шинэ (ctrl + N) товшино. Барааг баркодоор уншуулах болон хайлтаар түүвэрлэж оруулана. Нэг зарлаганд хэд хэдэн барааг нэгэн зэрэг зарлагадах боломжтой юм.

За	рлага							_ D X							
	Болих 💾 Хадгалах 🔊 Гар														
	Дугаар: 1														
	Актлав хугацаа дууссан														
	Баркод	Барааны нэр	Харилцагч	Тоо	Өртөг	Нийт өртөг	Өөрчилсөн	Өөрчилсөн огноо							
•	1	Талх	•	2	1,000	2,000									
						2,000									
4		Шина буртгал													

Тоо болон өртөг баганыг өөрчилнө. Тоо зарлагадаж буй тоо ширхэг юм. Өртөг нь тухайн барааг ирсэн үнээр нь эсвэл хичнээн төгрөгөөр зарлагадах нэгжийн үнийг оруулах юм.

Хадгалах товч нь оруулсан мэдээллийг зарлагын дугаараар нь хадгална. Буцаж орж засварлах болон устгах боломжтой. Барааны үлдэгдэл хараахан хасагдаагүй гэсэн үг юм.

Зарлага хаах товч нь гүйлгээг хадгалж мөн дахин устгах болон засварлах боломжгүйгээр гүйлгээг гүйцэтгэнэ. Зарлага хаагдсанаар барааны үлдэгдэл зарлагадах тооны дагуу хасагдсан байна.

Гүйлгээний утга талбарт Тухайн зарлагын учир шалтгааныг тэмдэглэж гараар оруулж өгөх юм.

Тооллого

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Гүйлгээ цэсний Тооллого дэд цэс

Тооллого хийхэд ямар нэгэн үечлэл болон тайлант үеэр бүгдийг хийх шаардлагагүй. Хэсэгчилэн тооллого хийх боломжтой. Барааг тасагаар болон нийлүүлэгчээр салган тооллогоо үүсгэж тоолсоны дараагаар тоолсон тоогоо оруулахад зөрсөн болон дутсан барааны үнийн дүн бодогдож харагдах юм. Тоолсон тооны дагуу тооллого хаахад үлдэгдэл өөрлөгдөх гүйгээ юм.

- Тоолого нь Хаагдсан болон Үүссэн гэсэн 2 төлөвтэй.
- Үүссэн тооллогонд багтсан бараа борлуулалт болон орлого, зарлагын гүйлгээгээр хийгдэх боломжгүй
- Хаагдсан тооллого нь устах болон засварлах боломжгүй.
- Тооллого үүсгэсэн бараа дахин дуудагдахгүй.
- Тооллого үүссэн бараа борлуулалт болон орлого зарлагын гүйлгээ хийгдэхгүй.
- Тооллого үүссэн бараанд үлдэгдэл хөдлөхгүй.
- Тооллогын хуудасны барааны дараалал бүртгэлийн дарааллын дагуу жагсана.

Тооллого										
Болих	Тооллого	үүсгэх Тооллого у	аах Барим	т 🦪 Гар						
Дугаар: 2										
Гүйлгээн	ний утга		Тасагаар		•	X				
⊠ Бүгдий	іг сонгох		Талх нари	Талх нарийн боов 🔹						
Сонгох	Баркод	Барааны нэр	Тоо	Тоолсон тоо	Зөрүү	Үнэ	Зөрүү дүн	Тоолсон дүн	Өөрчилсөн	Өөрчилсөн огноо
						1				
					0		0			
Дэлгэцийн төлөв :	Шинэ бүртгэл									

Шинэ тооллого үүсгэхдээ Шинэ (ctrl + N) дарахад дээрх зураг дээрх дэлгэц нээгдэнэ.

Бүх Бараа, Тасагаар, Нийлүүлэгчээр гэсэн 3 төрлөөр барааг дуудаж оруулаад Бүгдийг сонгох дараад **Тооллого үүсгэх** товчийг дарах юм.

Too	оллого										_ D X
	Болих	Хадгалах	Тооллого хаах	Баримт 🥥	Гар						
	Дугаар: 1										
	Гүйлгээ	ний утга				6					
	Сонгох	Баркод	Барааны нэр	Тоо	Тоолсон тоо	Зөрүү	Үнэ	Зөрүү дүн	Тоолсон дүн	Өөрчилсөн	Өөрчилсөн огноо
•	\checkmark	62810067	Липтон цай 25ш	15	12	-3	2,500	-7,500	30,000	Админ	2016.06.0
						-3		-7,500	30,000		
Д	элгэцийн төлөв :	Шинэ бүртгэл									

Үүссэн тооллогын барааны мэдээлэл жагсаалтаас харагдах бөгөөд Тоолсон тоо багананд Одоогын бодит үлдэгдэлийг тоо ширхэгийг оруулах юм. Ингэснээр автоматаар зөрүү тоо дүнг харуулна.

Тооллого хараахан дуусаагүй гэж үзвэл ХАДГАЛАХ (ctrl + S) дарж дараа нь засварлахаар орж үргэлжлүүлнэ. Хэрэв тооллого дуусч хаах болбол ТООЛЛОГО ХААХ (ctrl + T) товч дарах юм.

Тооллогын төхөөрөмжөөр Тооллого хийх боломжтой. Тухайн зааврыг видео хичээлээс дэлгэрэнгүй үзээрэй.

Авлага

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Гүйлгээ цэсний Тооллого дэд цэс

Авлага нь зээлээр бараа бүтээгдэхүүний борлуулсан үед үүснэ. Авлагыг хаах болон төлөлт хийх мөн лавлах боломжтой. Авлага нь хаагдсан болон үлдэгдэлтэй гэсэн үндсэн хоёр төлөвтэй. Борлуулалт дэлгэцны төлөлт цонхонд **Авлагаар** гэсэн төлөлтийг сонгоход бүртгэсэн харилцагчид харагдах ба тухайн харилцагчид авлага үүсгэнэ. Мөн авлага үүсгэх үедээ шинэ харилцагчийг бүртгэх боломжуудтай. Доод зурганд авлагын үндсэн жагсаалтын хэсэг. Үүнд БҮГД, ХААГДСАН АВЛАГА, ҮЛДЭГДЭЛТЭЙ АВЛАГА –аар шүүгдэнэ.

Авл	iara					_ D X
	🕂 Шинэ	Засах Шүүлт			Ì	
	О Бүгд	🔘 Хаагдсан авлага	Улдэгдэл	птэй авлага		
	Харилцагч код	Харилцагчын нэр	Нийт дүн	Төлсөн дүн	Үлдэгдэл	Төлөв байдал
	1	Баяр	15,000	ľ	15,000	Үлдэгдэлтэй авлага
			15,000	0	15,000	
144	4 1/1 F H 4					
Æ	олгэцийн төлөв :	Жагсаалтаар харах				

Тухайн авлагын мөрөнд товчшиход Тухайн харилцагчийн авлагын дэлгэрэнгүй харагдана. Доорх зургаас .

Авлага						_ D X								
Болих 💾 Төлөлт хийх 🗽 Авлага хаах 🧳 Гар														
Харилцагч	Харилцагч Нийт авлага Төлсөн дүн Үлдэгдэл													
Баяр	-	15,000 🗘	15,0	00 \$										
Төрөл	Эх гүйлгээ	Ажлын огноо	Тайлбар	Үүсгэсэн хэрэглэгч	Үүсгэсэн Огноо	Нийт дүн								
• Авлага	1	2016.06.17		Админ	2016.06.17 23:03:02	15,000								
						15,000								
H4 4 1/1 > >H	(÷								
Дэлгэцийн төлөв :	Засварлах													

Жагсаалтанд тус бүр үүссэн авлагууд харагдах ба нийт авлагын дүн болон үлдэгдэл нь дэлгэцийн дээд хэсэгт харагдана. Төлөлт хийхдээ **ТӨЛӨЛТ ХИЙХ** товчинд дарахад жижиг дэлгэц нээгдэнэ. Тухайн жижиг дэлгэцэнд төлсөн дүнг бичих юм. Хэрэв төлсөн дүн нь үлдэгдэлээс их байвал тухайн авлага шууд хаагдана. Хэрэв дутуу байвал авлага үлдэгдэлтэй хэсэгт үлдэх юм.

АВЛАГА ХААХ товшиход тухайн төлсөн харилцагчийн дүнг хийлгүйгээр шууд үлдэгдэлээр төлсөн болгож хаагдана.

Үнийн шошго хэвлэх

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Үнэ хэвлэх цэс

Үнийн шошгыг барааны үнийг цаасан дээр хэвлэж хэрэглэгчид туслах зорилгоор ашиглана. Хэвлэхдээ Кассын термо принтер болон энгийн лазер, өнгөт принтерүүдээр хэвлэх загваруудтай юм.

′нэ хэвлэх										
🚎 Үнэ харах, Хэвлэх		Шүүлт	Цэвэрлэх 👿 Хасах							
Fankon, fanaaraan nyynay		Баркод	Бараа	Үнэ	Хэвлэх тоо					
		1	Kaltenberg (0.5ml)	6,000	1					
Бөөн оруулах		3	Budweiser(0.33ml)	6,000	1					
Сүүлд нэмэгдсэн	•	4	Чингис хаан 0,33	4,000	1					
	Ψ.	5	Altan Gobi (0.33ml)	2,000	1					
Цаасны хэмжээ		7	Сэрүүн 0,45	2,500	1					
A4	•									
Принтер										
NPIFFA45A (HP Laser	•									
Урьдчилан харах										
Хэвлэх										
Гарах										

Барааг бөөнөөр болон нэг нэгээр нь дуудах боломжтой. Хэвлэх загварыг урьдчилан харна.

Цаасны хэмжээ нь 58мм, 80мм болон А4 гэсэн 3 сонголттой. Хэвлэх принтерийн сонголлтой.

Жагсаалтын дээд хэсэгт Шүүлт, Цэвэрлэх, Хасах гэсэн товчлууруудтай.

Баркод, бараагаар дуудах : Бараа тус бүрээр баркодыг уншуулж жагсаалтруу нэмнэ. Мөн ... товчоор сонгоно.

Бөөн оруулах : Барааг тасаг нийлүүлэгчээр болон сүүлд өөрчлөгдсөнөөр бөөнөөр жагсаалтруу оруулна.

Цаасны хэмжээ : 57mm болон 80 mm А4 гэсэн 3 загварын сонголтуудтай.

Шүүлт : Жагсаалтын дээд хэсэгт хоосон мөр үүсч харгалзах багананд бичихэд Шүүгдэнэ.

Цэвэрлэх : Жагсаалт дахь бүх барааг цэвэрлэнэ.

Хасах : Сонгогдсон барааг хасна.

Өдрийн тайлан

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Өдрийн тайлан дэд цэс

Эхлэх болон нийт

- ΗΘΑΤ •
- НХАТ
- Борлу орлог
- Буцаа
- Карта
- Авлаг
- Төлсө
- БЭЛН (Борл карта xacca
- Нийт •
- Эхни
- Бэлэн .
- Мөнг
- Эцсий
- НИЙТ ТУШААСАН Дэлгэцийн төлөв : Жагсаалтаар харах (Эхний үлдэгдэл болон Бэлэн мөнгө орлогыг нэмээд Тушаасан болон эцсийн үлдэгдлийг хасаад гарсан дүн.)

Тухайн тайлангаар БЭЛНЭЭР ДҮН болон НИЙТ ТУШААСАН ДҮН нь таарч байвал борлуулалт болон бэлэн мөнгийг шахаж тухайн өдрийн илүүдэл болон дутагдлийг ЗӨРҮҮ мөрөнд харуулах юм. Хэрэв ЗӨРҮҮ дүн нь о-с их бол дутагдалтай. о-с бага бол бэлэн мөнгөний илүүдэлтэй гэсэн үг юм. Түхайн тайлан нь Кассын принтерээр хэвлэх болон Эксел, PDF, А4 – р хэвлэх болон экспортлох боломжтой. Эхлэх болон дуусах огнооны хооронд болон Хэрэглэгчээр ангилах лавлах боломжтой.

Товчоо тайлан

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Товчоо тайлан дэд цэс

Товчоо тайлан нь үлдэгдэл хянах тайлан бөгөөд Эхний үлдэгдэл буюу Өмнөх тооллогын үлдэгдэлээс борлуулалт, буцаалт, орлого, зарлага , Эцсийн буюу одоогын үлдэгдэл хүртэлх түүхийг бараа тус бүрээр харах тайлан юм.

Тухайн тайлангийн гүйлгээнүүдийн тоон дээр 2 дарахад Тухайн гүйлгээний дэлгэцэнгүй түүх харагдах юм.

Мөн жагсаалтанд Баркод, Барааны нэр, Үнэ гэсэн багануудтай. Гүйлгээ тус бүрийн тоо болон дүн гэсэн багануудтай. Дүн багананд тухайн барааны ТООГ ҮНЭЭР ҮРЖҮҮЛЖСЭН үнийн дүнг харуулах юм. Өртөгийг нийлбэр дүнг оруулаагүй болно.

OTHOD: 2016.06.19 + -aac 20	16.06.19 - Бүгд	• Баримт хэвлэх
Гүйлгээний төрөл	Нийлбэр дүн	
 НӨАТ 	0	
HXAT	0	
Борлуулалт	0	
Буцаалт	0	
Картаар	0	
Авлага	0	
Гөлсөн авлага	0	
БЭЛНЭЭРДТН	0	
Нийт хөнгөлөлт	0	
	0	
Эхний үлдэгдэл	0	
Бэлэн мөнгө орлого	0	
Мөнгө тушаах	0	
Эцсийн үлдэгдэл	0	
НИЙТ ТУШААСАН	0	
	0	
ЗӨРҮҮ	0	
Устсан борлуулалт	0	
	Гүйлгээний төрөл НӨАТ НХАТ Борлуулалт Буцаалт Картаар Авлага Төлсөн авлага БЭЛНЭЭР ДҮН	Гүйлгээний төрөл Ныйлбэр дүн • НӨАТ 0 НХАТ 0 Борлуулалт 0 Буцаалт 0 Картаар 0 Авлага 0 Төлсөн авлага 0 БЭЛНЭЭР ДҮН 0

вчоо тайлан														
📚 Шүүлт 🚺 🔛 😂														
айлт														
Баркод	Барааны нэр	Үнэ	Эхний үлдэгдэл	Э.Ү дүн	Орлого	Орлого Дүн	Зарлага	Зарлага Дүн	Борлуулалт	Борлуулалт Дүн	Буцаалт	Буцаалт Дүн	Эцсийн үлдэгдэл	Эцсийн.Ү Дүн
41	Улаанбаатар	4,000	0	0	0	0	0	0	1	4,000	0	0	-1	-4,000
42	Экспорт 0.5	25,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
43	Улаанбаатар	20,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
44	Smirnoff 0.75	82,500	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
45	Finlandia 0.75	75,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
46	Soyombo 0.75	60,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
47	Bolor 0.75	45,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
48	Bolor (Cranbe	45,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
49	Bolor (Orange	45,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
50	Экспорт	37,500	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
51	Улаанбаатар	30,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
52	Smirnoff 1L	110,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
53	Finlandia 1L	100,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
54	Soyombo 1L	80,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
55	Jack Daniels 5	10,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
56	Johnnie walke	7,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
57	Johnnie walke	9,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
58	Jack Daniels 0	150,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
59	Johnnie walke	105,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
60	Johnnie walke	135,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
61	Jack Daniels 1L	200,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
60	Johnnio walko	140.000	n	n	n	n	n	0	n	n	n	n	n	n
			0	0	0	0	0	0	2	15,000	0	0	-2	-15,0

Борлуулалтууд

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Борлуулалтууд дэд цэс

Шүүлт Г ОГНОО : 2 Роз№ Дугаар	2012.06.19	-aac 2	016.06.19	- [> x												
Огноо: 2 РозNo Дугаар	2012.06.19	• -aac 2	016.06.19	- 🤇	X												
PosNo Дугаар	0				- ^	айлт											
	OTHOO	Цаг	Хэрэглэгчийн нэр	Нийт тоо	Нийт дүн	Хенгелелт	Татвар	Төлбөр хийгдсэн	Бэлнээр	Картаар	Авлагаар	Нийт төлсөн	Харилц код	Сүүлийн өөрчлөлт	Сүүлийн огноо	Төлөлт хийсэн	Төлсөн огноо
100001	1 2016.06.10	21:30:19	Зеегч 1	2	15,000	0	0	\checkmark	0	0	15,000	15,000		Зөөгч 1	2016.06.10 21:	Админ	2016.06.17 23:03
100001	2 2016.06.10	21:31:45	Админ	2	15,000	0	0							Админ	2016.06.10 21:		
W 4 1/2 - W 4 C				4	30,000	0	0		0	0	15,000	15,000					
m + 1/2 + HH +																	,

Эхлэх болон дуусах огнооны хоорондын нийт борлуулалтын толгой мөрүүд харагдах ба тухайн толгой мөрөнд 2 товшиход (Double Click) борлуулалтын дэлгэрэнгүй барааны мэдээлэл харагдана.

Буцаалтууд

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Буцаалтууд дэд цэс

Эхлэх болон дуусах огнооны хоорондын буцаалтын дэлгэрэнгүй мөрүүд харагдана.

Буц	аалтууд	үлт											_)(¤)(x
-	Огно	DO: 2016	.06.19	-aac 2016.	06.19	•							
Ē	Дугаар	Огноо	Цаг	Баркод	Барааны код	Барааны нэр	Үнийн төрөл	Борлуу	Буцаасан тоо	Үнэ	Буцаасан дүн	Бэлнээр	Картаар
+	3	2016.06.19	22:56:36	25	25	Coca cola	Жижиглэн	1	1	2,500	2,500	2,500	
	3	2016.06.19	22:56:37	26	26	Soda Schweppes	Жижиглэн	1	1	2,500	2,500	2,500	
	3	2016.06.19	22:56:39	32	32	Nuts	Жижиглэн	1	1	5,000	5,000	5,000	
	3	2016.06.19	22:56:40	33	33	Gum	Жижиглэн	1	1	1,000	1,000	1,000	
								4	4	11,000	11,000	11,000	0.
144	4 1/4	F # 4 C											1
Дэ	лгэцийн т	өлөв: Жагсаа	птаар харах										

Борлуулалт бараагаар

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Борлуулалт бараагаар дэд цэс

Бо	рлуулалт бар	aaraap							_ D X
	+ Шинэ	Шүүлт							
(Огноо:	2016.06.19	-aac	2016.0	6.19 -	Бүгд	•	🔁 Хайлт	Баримт хэвлэх
	Баркод	Барааны нэр	Tacar	Тоо	Үнэ	Үнийн дүн	Хотын татвар дүн	НӨАТ дүн	
•	25	Coca cola	Ус ундаа	2	2,500	5,000	1	454.55	
	26	Soda Schwep	Ус ундаа	1	2,500	2,500		227.27	
	27	JUICE MOR C	Ус ундаа	1	6,000	6,000		545.45	
	29	Red Bull (Yell	Ус ундаа	1	4,000	4,000		363.64	
	32	Nuts	Ус ундаа	1	5,000	5,000		454.55	
	33	Gum	Ус ундаа	1	1,000	1,000		90.91	
				7	21,000	23,500	0	2,136.36	
144	4 1/6 ► 1	H	nav						

Борлуулалт бараагаар тайланд эхлэх болон дуусах огнооны хоорондох борлуулалтын мэдээллийг бараагаар нь групп хийж борлуулсан тоо болон дүнг нэгтгэж нэмсэн мэдээллийг гаргана.

Тасагаар нь ялгаж харуулах боломжтой.

Кассын принтерээр мэдээллийг хэвлэх боломжтой.

Тухайн борлуулалтын мэдээлэлд буцаасан дүнг хасаагүй болохыг анхаараарай.

Борлуулалт өдрөөр

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Борлуулалт бараагаар дэд цэс

орлуулалт өдрөөр	и 🔂 Шүү	лт			
Огноо : 2	016.05.19	-aac	2016.06.1	9 • 🛜	Хайлт
Ажлын огноо	Нийт тоо	Нийт дүн	Нийт НӨАТ	Нийт HXAT	
2016.06.10	7	42,500	1,136.36	0	
2016.06.19	4	11,000	1,000	0	
	11	53,500	2 136 36	0	
4 4 1/2 ▶ ₩ 4		33,300	2,130.30	U	
Цэлгэцийн төлөв :	Жагсаалтаар хара	ĸ			

Эхлэх болон дуусах огнооны хугацааны борлуулалтыг өдөр тус бүрээр групп болгон өдөр тус бүрийн борлуулалтын Тоо, Нийт дүн, Нийт нэмэгдсэн өртөгийн албан татвар болон Нийслэл хотын албан татварын дүнг харуулах юм. Тухайн өдрийн мөрөнд 2 товшиход (Double Click) тухайн өдрийн дэлгэрэнгүй борлуулалтын мэдээллийг харуулах юм.

Ашгийн тайлан

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Ашгийн тайлан дэд цэс

Агшийн тайлан бараа тус бүрээр групп хийж Барааны нэр, Баркод , Борлуулсан тоо, Буцаасан тоо, Борлуулалтаас буцаалтыг хассан тоо , Нийт ББӨ (борлуулсан барааны өртөг), Нийд дүн , Ашиг гэсэн багануудтай.

Ашиг багананд Нийт ББӨ – с нийт дүнг хасаж харуулсан дүн юм. Энэ нь таны бараа материалаас олсон бохир ашиг юм.

Нийт ББӨ багананд тухайн борлуулсан бараа бүтээгдэхүүний Кассар бичилт хийгдэх үеийн өртөгийг тоогоор үржүүлсэн дүн юм.

Нийт дүн багананд тухайн борлууулсан бараа бүтээгдэхүүний Кассаар бичих үеийн үнийг тоогоор нь үржүүлсэн үнийн дүнг харуулна.

Ашгийн тайлан							-	
🔯 Шүүлт 🚺 🖞	Active Active	Z						
Огноо : 2016.06.	19 - aac	2016.00	5.19 -	>	(айлт			
Барааны нэр	Баркод	Борлуулсан тоо	Буцаасан тоо	Бор-Буц тоо	Нийт ББӨ	Нийт дүн	Ашиг	î
Coca cola	25	2	4	-2	0	-6,000	-6,000	
Soda Schweppes	26	1	4	-3	0	-8,500	-8,500	
ЈUICE МОЯ СЕМЬЯ	27	1	0	1	0	6,000	6,000	
Red Bull (Yellow)	29	1	0	1	0	4,000	4,000	
Nuts	32	1	4	-3	0	-6,000	-6,000	
		7	16	-9	0	-20,5	-20,5	-
₩ 4 1/6 + ₩ 4								•
Дэлгэцийн төлөв : Жагсаалтаа	р харах							

Гүйлгээний дэлгэрэнгүй

Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Гүйлгээний дэлгэрэнгүй дэд цэс

Ф Шүүлт			R								
Огноо	: 2016.06	. <mark>19</mark> - a	aac 2016.06	5.19 -							
Гүйлгээ	Огноо	Баркод	Барааны нэр	Тасгын нэр	Харилцагч	Тоо ширхэг	Өртөг	Нийт өртөг	Үнэ	Дүн	Тэмдэглэл
Борлуулалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Борлуулалт	2016.06.19	27	JUICE MOR C	Ус ундаа		1	0	0	6,000	6,000	
Борлуулалт	2016.06.19	29	Red Bull (Yell	Ус ундаа		1	0	0	4,000	4,000	
Борлуулалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Борлуулалт	2016.06.19	26	Soda Schwep	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Борлуулалт	2016.06.19	32	Nuts	Ус ундаа		1	0	0	5,000	5,000	
Борлуулалт	2016.06.19	33	Gum	Ус ундаа		1	0	0	1,000	1,000	
Буцаалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Буцаалт	2016.06.19	26	Soda Schwep	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Буцаалт	2016.06.19	32	Nuts	Ус ундаа		1	0	0	5,000	2,500	
Буцаалт	2016.06.19	33	Gum	Ус ундаа		1	0	0	1,000	2,500	
Буцаалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Буцаалт	2016.06.19	26	Soda Schwep	Ус ундаа		1	0	0	2,500	2,500	
Буцаалт	2016.06.19	32	Nuts	Ус ундаа		1	0	0	5,000	2,500	
Буцаалт	2016.06.19	33	Gum	Ус ундаа		1	0	0	1,000	2,500	
Буцаалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	5,000	
Буцаалт	2016.06.19	26	Soda Schwep	Ус ундаа		1	0	0	2,500	5,000	
Буцаалт	2016.06.19	32	Nuts	Ус ундаа		1	0	0	5,000	5,000	
Буцаалт	2016.06.19	33	Gum	Ус ундаа		1	0	0	1,000	5,000	
Буцаалт	2016.06.19	25	Coca cola	Ус ундаа		1	0	0	2,500	1,000	
F	2010 00 10	26	Code Colours				^	•	2.500	+ 000	
						23	0	0	67,500	67,500	

Гүйлгээний дэлгэрэнгүй тайланд Борлуулалт , Буцаалт, Эхний үлдэгдэл, Орлого , Зарлага , Тооллого зэрэг гүйлгээнүүдийн бүх бичилтүүд нэг дор дэлгэрэнгүйгээр харагдах юм. Харуулах багануудад :

Гүйлгээ (Гүйлгээний төрөл)

Огноо (Тухайн гүйлгээг хийх үеийн ажлын огноо) Баркод (Барааны зураасан код болон гар код) Тоо (Гүйлгээ хийсэн бараа бүтээгдэхүүний тоо ширхэг) Өртөг (Гүйлгээ хийх үеийн барааны худалдан авсан үнэ) Нийт өртөг (Тоог өртөгөөр үржүүлсэн дүнгийн нийлбэр) Үнэ (Гүйлгээ хийх үеийн барааны худалдах үнэ) Дүн (Тоог үнээр үржүүлсэн дүнгийн нийлбэр)

Борлуулалтын график



Үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах Тайлан цэсний Борлуулалтын график дэд цэс

1-р графикт Хамгийн их борлуулалттай 10 барааны борлуулалт (эхлэх дуусах огнооны хооронд)

2-р графикт Гүйлгээний дүнгийн цэгүүд өдөр өдрөөр гарна.

3-р графикт Эхлэх болон дуусах огнооны хоорондын борлуулалт тасагаар гарна.

АНХААРАЛ ТАВЬСАН ТАНД БАЯРЛАЛАА.